



Панятай
Танилц

Тайланд

дахь Есүсийг дагагч

Паня хэрхэн Есүсийг дагадаг вэ?

Паня үеэлээ Сүмд хамт явахад урьжээ. Түүнийг сүмд ирээд таатай байхад нь Паня тусалдаг. Тэр түүнд Хүүхдийн хэсгийн хүүхдүүдтэй танилцаж найзуудтай болоход нь тусалдаг.

Паня гэрийнхэндээ хоолны саваа угааж мөн гутлаа цэвэрлэж тусалдаг. “Бусдад туслах нь хөгжилтэй байдаг” гэж Паня хэлдэг. Тэр нагац эгч, эмээтэйгээ амьдардаг бөгөөд тэдэнд туслах дуртай. Тэр өглөө болгон хөнжлөө хураадаг.

Панягийн ээж нас бараад тийм ч удаагүй байгаа. Паняг ээжийгээ санах үед нагац эгч нь түүнд Тэнгэрлэг Эцэгтээ залбирахад нь тусалдаг. Тэр залбирсныхаа дараа хайр мэдэрдэг. “Намайг залбирах үед Есүс надтай хамт байгаа юм шиг санагддаг” гэж тэр хэлдэг. ●



Паня эмээ, нагац эгч хоёрынхоо хамт

Чи ч бас Есүсийг дагаж чадна!

Чи Есүсийг дагахын тулд юу хийсэн бэ? Бидэнд хандан бичиж мөн ярьж өгөөрэй! Хэрхэн илгээхийг арын хавтаснаас харна уу.



สวัสดี!



Панягийн тухай

НАС: 7

ХААНААС ИРСЭН:
Тайландын Нонтабури

ХЭЛ: Тай

ЗОРИЛГО: Интерьер дизайнер болох мөн байшин, барилга байгууламжийн дотоод засал хийх

ХОББИ: Бүжиглэх, дугуй унах, төгөлдөр хуур сурах, усанд сэлэх, унших мөн таеквондод явах

ГЭР БҮЛ: Паня, нагац эгч, эмээ

Панягийн дуртай зүйлс

ЕСҮСИЙН ТҮҮХ: Түүний баптисм хүртсэн түүх (Матай 3:13-17-г үзнэ үү)

АМРАЛТ, ГЭР БҮЛИЙН УЛАМЖЛАЛ: Христийн мэндэлсний баяр, гэр бүлийн аялал

ЖИМС, НОГОО: Ногоон усан үзэм, өргөст хэмх

ӨНГӨ: Нил ягаан

ХҮҮХДИЙН ХЭСГИЙН ДУУ: “Би ариун сүм харах дуртай” (Хүүхдийн дууны ном, 99)